



ДУНДГОВЬ АЙМАГ
БАЯНЖАРГАЛАН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 09 сарын 25 өдөр

Дугаар А/51

Аргатай

「 Баянжаргалан түншлэл-2023 үзэсгэлэн 」

Худалдаа зохион байгуулах тухай

Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ний өдрийн 61 дүгээр тушаалын 2.1.5, 2.1.6, Сумын Засаг даргын зөвлөлийн 01 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийнхаа үйлдвэрлэгчдийн борлуулалтыг дэмжих, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг сурталчлах, харилцан туршлага солилцох зорилгоор “Баянжаргалан түншлэл-2023” үзэсгэлэн худалдааг 2023 оны 9 дүгээр сарын 29-ний өдөр “Соёлын төв”-д зохион байгуулсугай.

2. “Баянжаргалан түншлэл-2023” үзэсгэлэн худалдаа зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар, шаардагдах зардлын тооцоог хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Үзэсгэлэн худалдаанд оролцсон байгууллага, аж ахуйн нэгж, үйлдвэрлэгчдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг шалгаруулах номинаци, шалгуур үзүүлэлтийг гаргаж, байгууллага, аж ахуйн нэгж, үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчийг өргөнөөр оролцуулж, үр дүнтэй зохион байгуулахыг ажлын хэсгийн ахлагч (Р.Отгонбаатар)-т үүрэг болгосугай.

4. Үзэсгэлэн худалдааны шагналд шаардлагатай 207900 (Хоёр зуун долоон мянга есөн зуу)-н төгрөгийг сумын Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргаж зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Р.Отгонбаатар), нягтлан бодогч (А.Цогзолмаа)-д тус тус зөвшөөрсүгэй.


ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

ЗАСАГ ДАРГЫН ТҮР

Б.ЗОЛЗАЯА

480701797

Сумын Засаг даргын 2023 оны 09 дүгээр сарын
25-ний өдрийн А/51 дүгээр захирамжийн нэгдүгээр
хавсралт



Ажлын хэсгийн дарга: Р.Отгонбаатар (Засаг даргын Тамгын газрын дарга)

Нарийн бичгийн дарга: Э.Сувд (Хүнс Хоршоо, ЖДҮ хариуцсан мэргэжилтэн)

Гишүүд: Т.Дуламханд (Санхүү албаны дарга)

Ц.Эрдэнэчимэг (Хөдөлмөр халамж үйлчилгээ хариуцсан
мэргэжилтэн)


Э.Дашдамба (Энгэр-Ус 2 дугаар багийн засаг дарга)

М.Мөнгөнхуяг (Шилийн гол 1 дүгээр багийн засаг дарга)

Б.Пүрэвбаяр (Аргатай 3 дугаар багийн засаг дарга)

Э.Хандсүрэн (Нягтлан бодогч)

Сумын Засаг даргын 2023 оны 09 дүгээр сарын
25-ний өдрийн А/51 дүгээр захирамжийн хоёрдугаар
хавсралт



Баянжаргалан түншлэл-2023 үзэсгэлэн худалдааны
Шагналын зардалын жагсаалт

№	Зардлын нэр	х/н	Тоо хэмжэ э	Үнэ	
				Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Сумын брэнд бүтээгдэхүүн	Ш	1	49500	49500
2	Шилдэг сүү сүүн бүтээгдэхүүн	Ш	1	49500	49500
3	Шилдэг газар тариалангийн бүтээгдэхүүн	Ш	1	49500	49500
4	Шилдэг хүнсний бусад нэрийн бүтээгдэхүүн	Ш	1	49500	49500
5	Хэрэглэгчийн таашаалд нийцсэн бүтээгдэхүүн	Ш	1	49500	49500
6	Хулдаасан хаяг	Ш	3	3300	9900
	Дүн				207900